



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/75

Хужирт сум

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын харьяат Монгол Улсын Ардын багш, Малын гавьяат эмч, Биологийн шинжлэх ухааны доктор, профессор, Академич Бадарчийн Бямбаа нас барсан тул ар гэрт нь 550 000 (таван зуун тавин мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.
2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ